

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны гуравдугаар сарын 26-ны 14 цаг 05 минутад эхэлж, 14 цаг 50 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 45 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Туулхангайн Ганбаатарыг Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Говь-Алтай аймгийн нутгийн захиргааны байгууллагын болон УИХ-ын Тамгын газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 03 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Говь-Алтай аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв</p>

		<p>комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 26 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Говь-Алтай аймагт 2015 оны 03 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 84 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 23 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 23 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөл /П.Золжаргал/-д үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 03 дугаар сарын 20-</p>
--	--	--

		<p>ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 26 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн “Хуралдааны тэмдэглэл хөтлөх асуудал хариуцсан шинжээч”-ийн сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэнийг “Ахлах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Ахлах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 1 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн

	<p>бичгийн даргыг томилох тухай</p>	<p>албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Архангай аймаг дахь Салбар зөвлөлийн даргын 2015 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 23 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн Эрдэнэсайханы Эрдэнэбаярыг 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Хоёр"-ын 1-д "...хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Пүрэвээгийн Бат-эрдэнэ" гэснийг "...Хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн Эрдэнэсайханы Эрдэнэбаяр" гэж өөрчлөх</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Э.Эрдэнэбаярт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Говьсүмбэр аймгийн Боловсролын газрын дарга М.Ганбаярын 2015 оны нэгдүгээр сарын 20-ны өдрийн А/01 тоот тушаалыг хүчингүй болгох тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь Салбар зөвлөлийн "Ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцсэн тухай" 2015 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоол болон Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр 39.5-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. "С.Энх-Амгаланд сахилгын шийтгэл ногдуулах тухай Говьсүмбэр аймгийн Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ганбаярын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/01 дүгээр тушаалыг</p>

		<p>хүчингүйд тооцох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолын биелэлтийг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу хангаж ажиллахыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл /Б.Батдэлгэрт/-д болон тус аймгийн Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ганбаяр нарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ